

САНХҮҮГИЙН МЭДЭЭЛЛИЙН АЛБАНД МЭДЭЭЛЭХ ҮҮРЭГТЭЙ ЭТГЭЭДЭЭС МЭДЭЭЛЭЛ ИРҮҮЛЭХ ЖУРАМ

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Энэ журмын зорилго нь Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 7 дугаар зүйл болон 9 дүгээр зүйлд заасны дагуу тус хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-д заасан Мэдээлэх үүрэгтэй этгээдээс 20 сая төгрөг, түүнээс дээш үнийн дүнтэй бэлэн мөнгөний болон гадаад төлбөр тооцооны гүйлгээ, сэжигтэй гүйлгээний мэдээллийг Санхүүгийн мэдээллийн албанд мэдээлэх, мэдээллийн нууцлал, аюулгүй байдлыг хангахтай холбоотой үйл ажиллагааг зохицуулахад оршино.

ХОЁР. БЭЛЭН МӨНГӨНИЙ БОЛОН ГАДААД ТӨЛБӨР ТООЦООНЫ ГҮЙЛГЭЭГ МЭДЭЭЛЭХ

2.1. Мэдээлэх үүрэгтэй этгээд нь дараах мэдээллийг гүйлгээ хийгдсэнээс хойш ажлын 5 (таван) өдрийн дотор батлагдсан маягтаар Санхүүгийн мэдээллийн алба (цаашид “СМА” гэх)-нд мэдээлнэ:

2.1.1. 20,0 (хорин) сая төгрөг (түүнтэй тэнцэх хэмжээний гадаад валют) болон түүнээс дээш дүнтэй бэлэн мөнгөний гүйлгээний мэдээллийг Бэлэн мөнгөний гүйлгээний тайлангийн маягт (Хавсралт 1)-аар мэдээлнэ;

2.1.2. 20,0 (хорин) сая төгрөг (түүнтэй тэнцэх хэмжээний гадаад валют) болон түүнээс дээш дүнтэй гадаад төлбөр тооцооны гүйлгээний мэдээллийг Гадаад төлбөр тооцооны гүйлгээний тайлангийн маягт (Хавсралт 2)-аар мэдээлнэ.

ГУРАВ. СЭЖИГТЭЙ ГҮЙЛГЭЭГ МЭДЭЭЛЭХ

3.1. Мэдээлэх үүрэгтэй этгээд нь хөрөнгө, гүйлгээ, гүйлгээ хийх оролдлогыг мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй, эсхүл гэмт

хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлоготой холбоотой гэж сэжиглэсэн, эсхүл мэдсэн бол энэ тухай 24 цагийн дотор Сэжигтэй гүйлгээний тайлангийн маягт (Хавсралт 3)-аар СМА-нд мэдээлнэ.

3.2. Хөрөнгө, гүйлгээ, гүйлгээ хийх оролдлогын талаарх мэдээллийг Сэжигтэй гүйлгээний тайлан (цаашид “СГТ” гэх)-аар мэдээлэхэд ямар нэгэн хязгаарлалт, үнийн дүн хамаарахгүй.

3.3. Мэдээлэх үүрэгтэй этгээд нь энэ журмын 3.1-д заасны дагуу СМА-нд мэдээлсэн сэжигтэй гүйлгээтэй холбогдох бусад баримт бичиг болон нэмэлт мэдээллийг СМА-наас шаардсан үед 24 цагийн дотор, цахим хэлбэрээр хүргүүлнэ.

3.4. СМА-нд мэдээлсэн сэжигтэй гүйлгээтэй холбоотой шинэ мэдээллийг тухайн мэдээллийн ач холбогдлоос хамаарч шинээр СГТ бөглөж эсхүл өмнө мэдээлсэн тайлангийн нэмэлт мэдээлэл хэлбэрээр хүргүүлж болно.

3.5. Мэдээлэх үүрэгтэй этгээд нь Бэлэн мөнгөний гүйлгээний тайлан (цаашид “БМГТ” гэх) эсхүл Гадаад төлбөр тооцооны гүйлгээний тайлан (цаашид “ГТТГТ” гэх)-аар мэдээлсэн, мэдээлэх гэж байгаа гүйлгээ нь сэжигтэй гүйлгээ байна гэж үзсэн тохиолдолд уг гүйлгээг СГТ-аар тусад нь, давхар мэдээлнэ.

3.6. Мэдээлэх үүрэгтэй этгээд түүний удирдлага, ажилтан нь гүйлгээний мэдээллийг СГТ-аар СМА-нд мэдээлсэн талаар уг тайланд нэр дурдагдсан харилцагч болон Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 7.4-т зааснаас бусад этгээдэд мэдэгдэх, дамжуулах, задруулахыг хориглоно.

3.7. Мэдээлэх үүрэгтэй этгээд нь СГТ, сэжигтэй гүйлгээний мэдээллийг СМА-нд мэдээлсэн ажилтны аюулгүй байдал, нууцлалыг хангах арга хэмжээг авч ажиллана.

ДӨРӨВ. СМА-НД СЭЖИГТЭЙ ГҮЙЛГЭЭТЭЙ ХОЛБОГДОХ БУСАД БАРИМТ БИЧИГ БОЛОН НЭМЭЛТ МЭДЭЭЛЭЛ ИРҮҮЛЭХ

4.1. СМА нь Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 9 дүгээр зүйлд заасны дагуу сэжигтэй гүйлгээтэй

холбогдох бусад баримт бичиг болон нэмэлт мэдээллийг Мэдээлэх үүрэгтэй этгээдээс гаргуулан авна.

4.2. СМА нь Мэдээлэх үүрэгтэй этгээдийн өөрийнх нь мэдээлсэн сэжигтэй гүйлгээтэй холбогдох бусад баримт бичиг болон нэмэлт мэдээлэл авах хүсэлтийг СМА-ны албан цахим шуудангийн хаягаар явуулах бөгөөд хариуг албаны цахим шуудангийн хаягаар цахим хэлбэрээр хүлээн авна.

4.3. Мэдээллийн бусад эх үүсвэрээс авсан сэжигтэй гүйлгээтэй холбогдох бусад баримт бичиг болон нэмэлт мэдээлэл авах хүсэлтийг СМА-ны дарга эсхүл түүнийг орлож байгаа албан тушаалтны гарын үсэгтэй албан бичгээр гаргах бөгөөд хариуг албан бичгээр, сэжигтэй гүйлгээтэй холбогдох бусад баримт бичиг болон нэмэлт мэдээллийг албаны цахим шуудангийн хаягаар цахим хэлбэрээр хүлээн авна.

4.4. СМА болон Мэдээлэх үүрэгтэй этгээдийн сэжигтэй гүйлгээтэй холбогдох бусад баримт бичиг болон нэмэлт мэдээлэл авах хүсэлт хүргүүлэх, хариу мэдээллийг ирүүлэхдээ мэдээллийг нууц үгээр хамгаалж илгээнэ. Мэдээллийн нууцлал, аюулгүй байдлыг хангах үүднээс нууц үгийг улирал тутамд эсхүл шаардлагатай тухай бүрт тогтмол өөрчилж байна.

4.5. СМА-наас сэжигтэй гүйлгээтэй холбогдох бусад баримт бичиг болон нэмэлт мэдээлэл авахаар хүргүүлсэн хүсэлтэд Мэдээлэх үүрэгтэй этгээд мэдээллийн хэмжээнээс хамааран ажлын 1-5 (нэгээс таван) өдрийн дотор хариулж, хүсэлтэд дурдсан шаардлагын дагуу хариуг бэлтгэн, цахим хэлбэрээр ирүүлнэ.

4.6. Мэдээлэх үүрэгтэй этгээд, түүний удирдлага, ажилтан нь сэжигтэй гүйлгээтэй холбогдох бусад баримт бичиг болон нэмэлт мэдээллийг СМА-нд мэдээлсэн талаар уг баримт бичиг, нэмэлт мэдээлэлд нэр дурдагдсан харилцагч болон Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 7.4-т зааснаас бусад этгээдэд мэдэгдэх, дамжуулах, задруулахыг хориглоно.

ТАВ. БМГТ, ГТТГТ БОЛОН СГТ-Д ТАВИГДАХ ШААРДЛАГА

5.1. Мэдээлэх үүрэгтэй этгээд нь БМГТ, ГТТГТ болон СГТ-г СМА-нд мэдээлэхдээ СГТ-г шаардлагатай тохиолдолд тухай бүр, БМГТ болон ГТТГТ-г тухайн долоо хоногийн гүйлгээнүүдийг нэгтгэн дараа долоо

хоногийн Даваа гарагт /нийтээр тэмдэглэх баярын өдөр таарсан бол дараагийн ажлын өдөр/ дараах байдлаар мэдээлнэ:

5.1.1.Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 4.1.1-д заасан Мэдээлэх үүрэгтэй этгээд нь тайлан, мэдээллийг банк хоорондын сүлжээгээр Монголбанкны Банкны тайлангийн системээр дамжуулан цахим хэлбэрээр СМА-ны мэдээллийн санд оруулна.

5.1.2.Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 4.1.2-4.1.9-д заасан Мэдээлэх үүрэгтэй этгээд нь тайлан, мэдээллийг зөвшөөрсөн сүлжээгээр дамжуулан цахим хэлбэрээр СМА-нд мэдээлнэ.

5.2. СМА-нд ирүүлэх тайлан дараах шаардлагыг хангасан байна:

5.2.1.БМГТ, ГТТГТ болон СГТ-г батлагдсан маягтаар, бүрэн, үнэн зөв, зааврын дагуу бөглөсөн байх;

5.2.2.БМГТ, ГТТГТ болон СГТ-г (Юникод) Unicode Монгол гарын драйвер ашиглан бэлтгэх;

5.2.3.БМГТ, ГТТГТ болон СГТ-д улс орны нэрийг ISO 3166-1. Улс орнуудын нэр болон болон түүний товчилсон тэмдэгтийн стандарт (Хавсралт 4)-ын дагуу бэлтгэх;

5.2.4.БМГТ, ГТТГТ болон СГТ-д гүйлгээ хийсэн валютын төрлийг ISO 4217. Улс орнуудын мөнгөн тэмдэгтийн нэр болон түүний товчилсон тэмдэгтийн стандарт (Хавсралт 5)-ын дагуу бэлтгэх.

5.3.Энэ журмын 5.1.1-д заасан Мэдээлэх үүрэгтэй этгээд нь БМГТ, ГТТГТ болон СГТ-г СМА-ны мэдээллийн санд оруулахын тулд Монголбанкны Үндэсний цахим гүйлгээний төв болон арилжааны банкуудыг холбосон сүлжээнд холбогдож, хэрэглэгчээр бүртгүүлсэн байх шаардлагатай.

5.4.СМА нь Мэдээлэх үүрэгтэй этгээдээс шаардлага хангасан тайлан ирүүлсэн эсхүл мэдээллийн санд оруулсан даруй тайлан хүлээн авсан тухай мэдэгдлийг Мэдээлэх үүрэгтэй этгээдэд явуулна.

5.5.Мэдээлэх үүрэгтэй этгээдээс ирүүлсэн эсхүл мэдээллийн санд оруулсан тайлан дутуу эсхүл алдаатай байгаа тохиолдолд тухайн тайланг

засаж дахин ирүүлэх буюу СМА-ны мэдээллийн санд оруулна. Энэ тохиолдолд Мэдээлэх үүрэгтэй этгээд нь СМА-ны fiu@mongolbank.mn хаяг руу тайлан устгуулах хүсэлт илгээнэ. Тайлан устгуулах хүсэлтэд Мэдээлэх үүрэгтэй этгээдийн нэр, тайланг мэдээлсэн огноо, тайлангийн дугаар /хэрэв мэдээллийн санд оруулсан тайлан бол/, тайлангийн нэр, гүйлгээний нийт тоо болон ямар учир шалтгаанаар тайлан устгуулах хүсэлт гаргаж байгаа талаар тодорхой бичсэн байна.

ЗУРГАА. МЭДЭЭЛЛИЙН НУУЦЛАЛ, АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ

6.1. Мэдээлэх үүрэгтэй этгээд нь БМГТ, ГТТГТ болон СГТ-г бэлтгэсэн, шилжүүлсэн, гүйлгээг мэдээлсэн тухай болон сэжигтэй гүйлгээтэй холбогдох бусад баримт бичиг, нэмэлт мэдээллийг шилжүүлсэн талаарх мэдээлэл, тэдгээрийн хуулбарыг байгууллагын болон хувь хүний нууцын тухай хууль тогтоомжийн дагуу чанд хадгална.

6.2. БМГТ, ГТТГТ болон СГТ-г мэдээлсэн, түүнтэй танилцсан ажилтанд дараах үйл ажиллагааг хориглоно:

6.2.1. Хууль тогтоомжийн дагуу БМГТ, ГТТГТ болон СГТ-тай холбоотой харилцагч, хувь хүн, хуулийн этгээдэд өөрт нь тайланг бэлтгэсэн, мэдээлэх гэж байгаа, мэдээлсэн тухай мэдэгдэх;

6.2.2. БМГТ, ГТТГТ болон СГТ-г бэлтгэсэн, мэдээлэх гэж байгаа, мэдээлсэн тухай хууль тогтоомжид заасан эрх бүхий байгууллагын эрх бүхий албан тушаалтнаас өөр этгээдэд мэдээлэх;

ДОЛОО. БУСАД

7.1. СМА нь Мэдээлэх үүрэгтэй этгээдээс ирүүлсэн БМГТ, ГТТГТ болон СГТ-ийн талаарх нэгдсэн статистик мэдээллийг улирал тутамд гаргаж, Монголбанкны вэб хуудас дээр байршуулна.

НАЙМ. ХАРИУЦЛАГА

8.1. Энэ журмыг зөрчсөн этгээдэд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

8.2. Мэдээлэх үүрэгтэй этгээд нь СМА-нд мэдээлсэн тайлан, мэдээллийн үнэн зөв байдлыг бүрэн хариуцна. Алдаатай тайлан, мэдээлэл ирүүлсэн бөгөөд энэ журмын 5.5-д заасныг биелүүлээгүй тохиолдолд

холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

-----oOo-----

Бэлэн мөнгөний гүйлгээний тайлангийн маягт

	№	1	2	3
А ХЭСЭГ Бэлэн мөнгөний гүйлгээ хийж байгаа этгээдийн мэдээлэл	1.Эцгийн нэр			
	2.Өөрийн нэр			
	3.Ургийн овог			
	4.Бусад нэр			
	5.Төрсөн улс			
	6.Харьяалал			
	7.Төрсөн огноо			
	8.Биеийн байцаалтын төрөл			
	9.Биеийн байцаалт дугаар			
	10.Регистрийн дугаар			
	11.Оршин суугаа хаяг			
	12.Утас			
	13.Эрхэлсэн ажил, мэргэжил, үйл ажиллагаа			
	14.Ажлын газрын нэр, хаяг, утас			
Б ХЭСЭГ Бусдаар төлөөлүүлэн гүйлгээ хийж байгаа этгээдийн мэдээлэл	15.Хувь хүн/ байгууллагын нэр			
	16.Бусад нэр			
	17.Төрсөн улс			
	18.Харьяалал			
	19.Төрсөн огноо			
	20.Биеийн байцаалтын төрөл (Гэрчилгээний төрөл)			
	21.Биеийн байцаалтын дугаар (Гэрчилгээний дугаар)			
	22.Ажил/ бизнес/ мэргэжил/ үйл ажиллагаа			
	23.Ажлын газрын нэр, хаяг, утас			
В ХЭСЭГ Гүйлгээ, дансны тухай мэдээлэл	24.Гүйлгээний нийт дүн			
	25.Гүйлгээ хийгдсэн огноо			
	26.Валют			
	27.Дансны дугаар			
	28.Гүйлгээний төрөл:			
	29.Данс эзэмшигчийн бүтэн нэр			
	30.Хаяг			
	31.Утас			
Г ХЭСЭГ Гүйлгээнд оролцогч нөгөө талын мэдээлэл	32.Хүлээн авагч/ Шилжүүлэгчийн нэр			
	33.Утас			
	34.Хүлээн авагч/ Шилжүүлэгчийн хаяг			
	35.Гүйлгээний утга			
	36. Гүйлгээнд оролцогч нөгөө талын дансны дугаар			
	37.Хүлээн авагч/ Шилжүүлэгчийн банк			
Д ХЭСЭГ Мэдээлэх үүрэгтэй этгээдийн талаарх мэдээлэл	38.Мэдээлэх үүрэгтэй этгээдийн нэр			
	39.Хаяг			
	40.Гэрчилгээний дугаар			
	41.Энэхүү тайланг бэлтгэсэн ажилтны овог, нэр			
	42.Албан тушаал			
	43. Тайланг хянасан ажилтны овог, нэр			
	44.Албан тушаал			
	45.Холбоо барих утас			
	46.Э-мэйл хаяг			
	47.Тайланг бэлтгэсэн огноо			

Гадаад төлбөр тооцооны гүйлгээний тайлангийн маягт

	№	1	2	3
А ХЭСЭГ. Гуйвуулагч байгууллага, хувь хүний талаарх мэдээлэл	1.Эцгийн нэр эсхүл Байгууллагын нэр			
	2.Өөрийн нэр			
	3.Ургийн овог			
	4.Харъяалал			
	5.Төрсөн огноо			
	6.Бичиг баримтын төрөл			
	7.Бичиг баримтын дугаар			
	8.Регистрийн дугаар			
	9.Оршин суугаа хаяг			
	10.Холбоо барих утас			
	11.Эрхэлдэг ажил, бизнесийн үйл ажиллагаа эсхүл албан тушаал			
	12.Ажлын газрын нэр, хаяг, утас			
	13.Гүйлгээг өөр хүн /итгэмжлэгдсэн төлөөлөгч/ хийсэн бол түүний Овог нэр			
	14.Бичиг баримтын дугаар			
	15.Эрхэлдэг ажил, бизнесийн үйл ажиллагаа эсхүл албан тушаал			
Б ХЭСЭГ. Хүлээн авагч байгууллага, хувь хүний талаарх мэдээлэл	16.Эцгийн нэр эсхүл Байгууллагын нэр			
	17.Өөрийн нэр			
	18.Ургийн овог			
	19.Харъяалал			
	20.Төрсөн огноо			
	21.Бичиг баримтын төрөл			
	22.Бичиг баримтын дугаар			
	23.Регистрийн дугаар			
	24.Оршин суугаа хаяг			
	25.Холбоо барих утас			
	26.Эрхэлдэг ажил, бизнесийн үйл ажиллагаа эсхүл албан тушаал			
	27.Ажлын газрын нэр, хаяг, утас			
	28.Гүйлгээг өөр хүн /итгэмжлэгдсэн төлөөлөгч/ хийсэн бол түүний Овог нэр			
	29.Бичиг баримтын дугаар			
	30.Эрхэлдэг ажил, бизнесийн үйл ажиллагаа эсхүл албан тушаал			
В ХЭСЭГ. Гүйлгээний талаарх мэдээлэл	31.Гүйлгээ хийгдсэн огноо			
	32.Гарсан гүйлгээний дүн			
	33.Орсон гүйлгээний дүн			
	34.Валютын нэгж			
	35.Гүйлгээний утга / Төлбөрийн зориулалт			
	36.Гүйлгээ хийсэн буюу төлбөр шилжүүлсэн банкны код			
	37.Гүйлгээ хийсэн буюу төлбөр шилжүүлсэн банкны нэр			
	38.Гүйлгээ хийсэн буюу төлбөр шилжүүлсэн банкны хаяг			
	39.Гүйлгээ хийгдсэн дансны дугаар			
	40.Гүйлгээг хүлээн авсан банкны код			
	41.Гүйлгээг хүлээн авсан банкны нэр			
	42.Гүйлгээг хүлээн авсан банкны хаяг			
	43.Гүйлгээг хүлээн авсан банкны дансны дугаар			
	44.Төлбөр гүйцэтгэгчийн корреспондент банкны нэр			
Г ХЭСЭГ. Гүйлгээтэй холбоотой нэмэлт мэдээлэл	45.Төлбөр гүйцэтгэгчийн корреспондент банкны оршин байгаа хот, улс			
	46.Хүлээн авагчийн корреспондент банкны нэр			
	47.Хүлээн авагчийн корреспондент банкны оршин байгаа хот, улс			
	48.Шилжүүлэгчээс хүлээн авагчид дамжуулсан мэдээлэл			
Д ХЭСЭГ. Мэдээлэх үүрэгтэй этгээдийн талаарх мэдээлэл	49.Мэдээлэх үүрэгтэй этгээдийн нэр			
	50.Хаяг			
	51.Гэрчилгээний дугаар			
	52.Энэхүү тайланг бэлтгэсэн ажилтны овог, нэр			
	53.Албан тушаал			
	54.Тайланг хянасан ажилтны овог, нэр			
	55.Албан тушаал			
	56.Холбоо барих утас			
	57.Э-мэйл хаяг			
	58.Тайланг бэлтгэсэн огноо			

Сэжигтэй гүйлгээний тайлангийн маягт

	№	1	2	3
А ХЭСЭГ Сэжигтэй Гүйлгээг Хийж Байгаа Этгээдийн Талаарх Мэдээлэл	1.Эцгийн нэр			
	2.Хувь хүн/ байгууллагын нэр			
	3.Ургийн овог			
	4.Бусад нэр			
	5.Төрсөн улс			
	6.Харьяалал			
	7.Төрсөн огноо			
	8.Хүйс			
	9.Биеийн байцаалтын төрөл (Гэрчилгээний төрөл)			
	10.Биеийн байцаалтын дугаар (Гэрчилгээний дугаар)			
	11.Регистрийн дугаар			
	12.Оршин суугаа хаяг			
	13.Утас			
	14.Эрхэлсэн ажил, мэргэжил, үйл ажиллагаа			
	15.Ажлын газрын нэр, хаяг, утас			
Б ХЭСЭГ. Сэжигтэй Гүйлгээ Болон Түүнд Оролцож Байгаа Дансны Талаарх Мэдээлэл	16.Гүйлгээний нийт дүн			
	17.Гүйлгээ хийгдсэн огноо			
	18.Валют			
	19.Дансны дугаар			
	20.Гүйлгээний утга			
	21.Данс эзэмшигчийн бүтэн нэр			
	22.Энэ гүйлгээнд оролцсон бусад банкны нэр, хаяг			
	23.Энэ гүйлгээнд оролцсон бусад дансны дугаар			
	24.Бусад банкин дахь данс эзэмшигчийн бүтэн нэр			
В ХЭСЭГ. Сэжиглэх Үндэслэл	25.Сэжиглэх үндэслэл			
	26.Тайлбар			
Г ХЭСЭГ. Мэдээлэх Үүрэгтэй Этгээдийн Талаарх Мэдээлэл	27.Мэдээлэх үүрэгтэй этгээдийн нэр			
	28.Хаяг			
	29.Гэрчилгээний дугаар			
	30.Энэхүү тайланг бэлтгэсэн ажилтны овог, нэр			
	31.Албан тушаал			
	32.Тайланг хянасан ажилтны овог, нэр			
	33.Албан тушаал			
	34.Холбоо барих утас			
	35.Э-мэйл хаяг			
36.Тайланг бэлтгэсэн огноо				

ISO 3166-1. Улс, орнуудын нэр болон түүний товчилсон тэмдэгтийн стандарт

Value	Country name
AF	Afghanistan
AX	Åland Islands
AL	Albania
DZ	Algeria
AS	American Samoa
AD	Andorra
AO	Angola
AI	Anguilla
AQ	Antarctica
AG	Antigua and Barbuda
AR	Argentina
AM	Armenia
AW	Aruba
AU	Australia
AT	Austria
AZ	Azerbaijan
BS	Bahamas
BH	Bahrain
BD	Bangladesh
BB	Barbados
BY	Belarus
BE	Belgium
BZ	Belize
BJ	Benin
BM	Bermuda
BT	Bhutan
BO	Bolivia (Plurinational State of)
BQ	Bonaire, Sint Eustatius and Saba
BA	Bosnia and Herzegovina
BW	Botswana
BV	Bouvet Island
BR	Brazil
IO	British Indian Ocean Territory
BN	Brunei Darussalam
BG	Bulgaria
BF	Burkina Faso
BI	Burundi
CV	Cabo Verde
KH	Cambodia
CM	Cameroon
CA	Canada
KY	Cayman Islands

CF	Central African Republic
TD	Chad
CL	Chile
CN	China
CX	Christmas Island
CC	Cocos (Keeling) Islands
CO	Colombia
KM	Comoros
CG	Congo
CD	Congo, Democratic Republic of the
CK	Cook Islands
CR	Costa Rica
CI	Côte d'Ivoire
HR	Croatia
CU	Cuba
CW	Curaçao
CY	Cyprus
CZ	Czechia
DK	Denmark
DJ	Djibouti
DM	Dominica
DO	Dominican Republic
EC	Ecuador
EG	Egypt
SV	El Salvador
GQ	Equatorial Guinea
ER	Eritrea
EE	Estonia
SZ	Eswatini
ET	Ethiopia
FK	Falkland Islands (Malvinas)
FO	Faroe Islands
FJ	Fiji
FI	Finland
FR	France
GF	French Guiana
PF	French Polynesia
TF	French Southern Territories
GA	Gabon
GM	Gambia
GE	Georgia
DE	Germany
GH	Ghana
GI	Gibraltar
GR	Greece
GL	Greenland
GD	Grenada
GP	Guadeloupe
GU	Guam

GT	Guatemala
GG	Guernsey
GN	Guinea
GW	Guinea-Bissau
GY	Guyana
HT	Haiti
HM	Heard Island and McDonald Islands
VA	Holy See
HN	Honduras
HK	Hong Kong
HU	Hungary
IS	Iceland
IN	India
ID	Indonesia
IR	Iran (Islamic Republic of)
IQ	Iraq
IE	Ireland
IM	Isle of Man
IL	Israel
IT	Italy
JM	Jamaica
JP	Japan
JE	Jersey
JO	Jordan
KZ	Kazakhstan
KE	Kenya
KI	Kiribati
KP	Korea (Democratic People's Republic of)
KR	Korea, Republic of
KW	Kuwait
KG	Kyrgyzstan
LA	Lao People's Democratic Republic
LV	Latvia
LB	Lebanon
LS	Lesotho
LR	Liberia
LY	Libya
LI	Liechtenstein
LT	Lithuania
LU	Luxembourg
MO	Macao
MK	Macedonia, the former Yugoslav Republic of
MG	Madagascar
MW	Malawi
MY	Malaysia
MV	Maldives
ML	Mali
MT	Malta
MH	Marshall Islands

MQ	Martinique
MR	Mauritania
MU	Mauritius
YT	Mayotte
MX	Mexico
FM	Micronesia (Federated States of)
MD	Moldova, Republic of
MC	Monaco
MN	Mongolia
ME	Montenegro
MS	Montserrat
MA	Morocco
MZ	Mozambique
MM	Myanmar
NA	Namibia
NR	Nauru
NP	Nepal
NL	Netherlands
NC	New Caledonia
NZ	New Zealand
NI	Nicaragua
NE	Niger
NG	Nigeria
NU	Niue
NF	Norfolk Island
MP	Northern Mariana Islands
NO	Norway
OM	Oman
PK	Pakistan
PW	Palau
PS	Palestine, State of
PA	Panama
PG	Papua New Guinea
PY	Paraguay
PE	Peru
PH	Philippines
PN	Pitcairn
PL	Poland
PT	Portugal
PR	Puerto Rico
QA	Qatar
RE	Réunion
RO	Romania
RU	Russian Federation
RW	Rwanda
BL	Saint Barthélemy
SH	Saint Helena, Ascension and Tristan da Cunha
KN	Saint Kitts and Nevis
LC	Saint Lucia

MF	Saint Martin (French part)
PM	Saint Pierre and Miquelon
VC	Saint Vincent and the Grenadines
WS	Samoa
SM	San Marino
ST	Sao Tome and Principe
SA	Saudi Arabia
SN	Senegal
RS	Serbia
SC	Seychelles
SL	Sierra Leone
SG	Singapore
SX	Sint Maarten (Dutch part)
SK	Slovakia
SI	Slovenia
SB	Solomon Islands
SO	Somalia
ZA	South Africa
GS	South Georgia and the South Sandwich Islands
SS	South Sudan
ES	Spain
LK	Sri Lanka
SD	Sudan
SR	Suriname
SJ	Svalbard and Jan Mayen
SE	Sweden
CH	Switzerland
SY	Syrian Arab Republic
TW	Taiwan, Province of China[a]
TJ	Tajikistan
TZ	Tanzania, United Republic of
TH	Thailand
TL	Timor-Leste
TG	Togo
TK	Tokelau
TO	Tonga
TT	Trinidad and Tobago
TN	Tunisia
TR	Turkey
TM	Turkmenistan
TC	Turks and Caicos Islands
TV	Tuvalu
UG	Uganda
UA	Ukraine
AE	United Arab Emirates
GB	United Kingdom of Great Britain and Northern Ireland
US	United States of America
UM	United States Minor Outlying Islands
UY	Uruguay

UZ	Uzbekistan
VU	Vanuatu
VE	Venezuela (Bolivarian Republic of)
VN	Viet Nam
VG	Virgin Islands (British)
VI	Virgin Islands (U.S.)
WF	Wallis and Futuna
EH	Western Sahara
YE	Yemen
ZM	Zambia
ZW	Zimbabwe

**ISO 4217. Улс, орнуудын мөнгөн тэмдэгтийн нэр болон түүний
товчилсон тэмдэгтийн стандарт**

AED	United Arab Emirates dirham
AFN	Afghan afghani
ALL	Albanian lek
AMD	Armenian dram
ANG	Netherlands Antillean guilder
AOA	Angolan kwanza
ARS	Argentine peso
AUD	Australian dollar
AWG	Aruban florin
AZN	Azerbaijani manat
BAM	Bosnia and Herzegovina convertible mark
BBD	Barbados dollar
BDT	Bangladeshi taka
BGN	Bulgarian lev
BHD	Bahraini dinar
BIF	Burundian franc
BMD	Bermudian dollar
BND	Brunei dollar
BOB	Boliviano
BOV	Bolivian Mvdol (funds code)
BRL	Brazilian real
BSD	Bahamian dollar
BTN	Bhutanese ngultrum
BWP	Botswana pula
BYN	Belarusian ruble
BZD	Belize dollar
CAD	Canadian dollar
CDF	Congolese franc
CHE	WIR Euro (complementary currency)
CHF	Swiss franc
CHW	WIR Franc (complementary currency)
CLF	Unidad de Fomento (funds code)
CLP	Chilean peso
CNY	Renminbi (Chinese) yuan[8]
COP	Colombian peso
COU	Unidad de Valor Real (UVR) (funds code)[9]
CRC	Costa Rican colon
CUC	Cuban convertible peso
CUP	Cuban peso
CVE	Cape Verde escudo
CZK	Czech koruna

DJF	Djiboutian franc
DKK	Danish krone
DOP	Dominican peso
DZD	Algerian dinar
EGP	Egyptian pound
ERN	Eritrean nakfa
ETB	Ethiopian birr
EUR	Euro
FJD	Fiji dollar
FKP	Falkland Islands pound
GBP	Pound sterling
GEL	Georgian lari
GHS	Ghanaian cedi
GIP	Gibraltar pound
GMD	Gambian dalasi
GNF	Guinean franc
GTQ	Guatemalan quetzal
GYD	Guyanese dollar
HKD	Hong Kong dollar
HNL	Honduran lempira
HRK	Croatian kuna
HTG	Haitian gourde
HUF	Hungarian forint
IDR	Indonesian rupiah
ILS	Israeli new shekel
INR	Indian rupee
IQD	Iraqi dinar
IRR	Iranian rial
ISK	Icelandic króna
JMD	Jamaican dollar
JOD	Jordanian dinar
JPY	Japanese yen
KES	Kenyan shilling
KGS	Kyrgyzstani som
KHR	Cambodian riel
KMF	Comoro franc
KPW	North Korean won
KRW	South Korean won
KWD	Kuwaiti dinar
KYD	Cayman Islands dollar
KZT	Kazakhstani tenge
LAK	Lao kip
LBP	Lebanese pound
LKR	Sri Lankan rupee
LRD	Liberian dollar
LSL	Lesotho loti
LYD	Libyan dinar
MAD	Moroccan dirham

MDL	Moldovan leu
MGA	Malagasy ariary
MKD	Macedonian denar
MMK	Myanmar kyat
MNT	Mongolian tögrög
MOP	Macanese pataca
MRU[13]	Mauritanian ouguiya
MUR	Mauritian rupee
MVR	Maldivian rufiyaa
MWK	Malawian kwacha
MXN	Mexican peso
MXV	Mexican Unidad de Inversion (UDI) (funds code)
MYR	Malaysian ringgit
MZN	Mozambican metical
NAD	Namibian dollar
NGN	Nigerian naira
NIO	Nicaraguan córdoba
NOK	Norwegian krone
NPR	Nepalese rupee
NZD	New Zealand dollar
OMR	Omani rial
PAB	Panamanian balboa
PEN	Peruvian sol
PGK	Papua New Guinean kina
PHP	Philippine peso[14]
PKR	Pakistani rupee
PLN	Polish złoty
PYG	Paraguayan guaraní
QAR	Qatari riyal
RON	Romanian leu
RSD	Serbian dinar
RUB	Russian ruble
RWF	Rwandan franc
SAR	Saudi riyal
SBD	Solomon Islands dollar
SCR	Seychelles rupee
SDG	Sudanese pound
SEK	Swedish krona/kronor
SGD	Singapore dollar
SHP	Saint Helena pound
SLL	Sierra Leonean leone
SOS	Somali shilling
SRD	Surinamese dollar
SSP	South Sudanese pound
STN[15]	São Tomé and Príncipe dobra
SVC	Salvadoran colón
SYP	Syrian pound

SZL	Swazi lilangeni
THB	Thai baht
TJS	Tajikistani somoni
TMT	Turkmenistan manat
TND	Tunisian dinar
TOP	Tongan pa'anga
TRY	Turkish lira
TTD	Trinidad and Tobago dollar
TWD	New Taiwan dollar
TZS	Tanzanian shilling
UAH	Ukrainian hryvnia
UGX	Ugandan shilling
USD	United States dollar
USN	United States dollar (next day) (funds code)
UYI	Uruguay Peso en Unidades Indexadas (URUIURUI) (funds code)
UYU	Uruguayan peso
UYW	Unidad previsional[16]
UZS	Uzbekistan som
VES	Venezuelan bolívar soberano[14]
VND	Vietnamese đồng
VUV	Vanuatu vatu
WST	Samoan tala
XAF	CFA franc BEAC
XAG	Silver (one troy ounce)
XAU	Gold (one troy ounce)
XBA	European Composite Unit (EURCO) (bond market unit)
XBB	European Monetary Unit (E.M.U.-6) (bond market unit)
XBC	European Unit of Account 9 (E.U.A.-9) (bond market unit)
XBD	European Unit of Account 17 (E.U.A.-17) (bond market unit)
XCD	East Caribbean dollar
XDR	Special drawing rights
XOF	CFA franc BCEAO
XPD	Palladium (one troy ounce)
XPF	CFP franc (franc Pacifique)
XPT	Platinum (one troy ounce)
XSU	SUCRE
XTS	Code reserved for testing purposes
XUA	ADB Unit of Account
XXX	No currency
YER	Yemeni rial
ZAR	South African rand
ZMW	Zambian kwacha
ZWL	Zimbabwean dollar